



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Адаацаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/99/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2026 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Т.Батсайхан Утас: 70592225 Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит ХХК Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
3.2 Зөвлөмж.....	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.24

№

49

танай

-ны №

-т

ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Л.БАДАМХАНД

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Адаацаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дундговь аймгийн Адаацаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дотуур байрны хүүхдийн хоолны нормыг хэтрүүлэн зарцуулсан, бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бүртгэсэн зэрэг 28,492.50 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 36.3 хувиар их байна.

Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолын 2 дахь хэсэг, Сангийн сайдын 2025 оны АЗ дугаар хавсралтын 10 дугаар 10.1-т заасан заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын засгийн газрын Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 195,436.0 мянган төгрөгөөр өссөн

4826050169

байна. Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 72 дугаар тогтоолоор 1982 онд ашиглалтад орсон 130,140.2 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 52 хүүхдийн дотуур байрыг акталж, данснаас хассан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 87 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 87.5 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	233,284,333.42	306,501,720.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	76,382,280.43	111,623,084.80
312	Банканд байгаа бэлэн мөнгө	76,382,280.43	111,623,084.80
3121	Төгрөг	76,382,280.43	111,623,084.80
31211	Төрийн сангийн харилцах	71,367,280.43	111,623,084.80
31218	Ахмадын сангийн харилцах	5,015,000.00	-
33	АВЛАГА	5,721,278.00	6,641,278.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,485,624.00	1,485,624.00
33300	Гатаас, санхүүжилтийн авлага	-	920,000.00
335	Бусад авлага	4,235,654.00	4,235,654.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,235,654.00	4,235,654.00
35	БАРАА МАТЕРИАЛ	151,180,774.99	188,237,357.72
351	Түүхий эд материал	83,234,502.91	108,958,362.45
35110	Тусгай зориулалттай материал	83,210,002.91	108,933,862.45
35130	Эм боох материал	24,500.00	24,500.00
354	Хангамжийн материал	67,452,272.08	78,699,995.27
35410	Бичиг хэргийн материал	763,100.00	624,600.00
35420	Аж ахуйн материал	36,829,712.08	55,425,685.27
35450	Барилгын засварын материал	4,635,600.00	2,338,600.00
35460	Хүнсний материал	13,342,060.00	8,429,310.00
35470	Бусад хангамжийн материал	11,881,800.00	11,881,800.00
35600	Мал амьтад	494,000.00	579,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,353,073,274.19	3,165,699,929.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,353,073,274.19	3,165,699,929.37
392	Биет хөрөнгө	3,309,358,774.19	3,122,382,929.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,483,187,132.68	3,312,420,190.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	(391,435,328.55)	(462,101,694.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,300,000.00	15,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,300,000.00)	(15,300,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,739,309.00	261,021,599.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(69,168,575.39)	(88,945,037.47)
39207	Гавилга, аж ахуйн эд хогшил	78,867,329.64	109,073,009.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(45,639,457.23)	(45,821,126.53)
39217	Ном	29,808,364.04	36,735,987.94
393	Биет бус хөрөнгө	43,714,500.00	43,317,000.00
39301	Программ хангамж	1,192,500.00	1,192,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(397,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	42,522,000.00	42,522,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,586,357,607.61	3,472,201,649.89
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,024,160.00	37,000,800.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,024,160.00	37,000,800.00
413	Өглөг	30,024,160.00	37,000,800.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	30,024,160.00	37,000,800.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,556,333,447.61	3,435,200,849.89
51	Засгийн газрын хувь оролцоо	3,556,333,447.61	3,435,200,849.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	897,971,845.05	897,971,845.05
51101	Өмч: - төрийн	897,971,845.05	897,971,845.05
512	Хуримтлагдсан үр дүн	2,024,402,386.51	1,903,269,788.79
51210	Өмнөх үеийн үр дүн	2,024,402,386.51	2,024,402,386.51
51220	Гайлантад үеийн үр дүн	-	(121,132,597.73)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	633,959,216.05	633,959,216.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,586,357,607.61	3,472,201,649.89

2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	1,891,085,199.50	2,089,306,701.90
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	275,751,199.50	174,640,101.90
1200	Нийтлэг татварын бус орлого	275,751,199.50	174,640,101.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,741,040.00	3,273,524.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	220,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	9,741,040.00	3,053,524.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	260,111,919.50	115,662,923.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,898,240.00	55,703,654.00
13	ГАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,615,334,000.00	1,914,666,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,430,089,200.00	1,671,265,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,430,089,200.00	1,671,265,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	185,244,800.00	243,401,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	185,244,800.00	243,401,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,753,121,499.30	2,091,089,898.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,753,121,499.30	2,091,089,898.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,717,631,888.74	2,027,426,665.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,108,648,101.00	1,304,084,126.00
210101	Үндсэн цалин	680,581,927.00	721,450,181.00
210102	Нэмэгдэл	383,938,904.00	500,646,857.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	40,825,421.00
210104	Урамшуулал	44,127,270.00	41,161,667.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,599,806.00	159,968,117.00
210201	Гэтгэврийн даатгал	92,189,578.00	111,393,254.00
210202	Гэтгэмжийн даатгал	10,812,434.00	13,032,187.00
210203	ҮОМШО-ний даатгал	5,432,590.00	6,516,120.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,279,370.00	5,805,312.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,885,834.00	23,221,244.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,491,838.44	227,544,246.70
210301	Гэрэл, цахилгаан	11,031,511.24	12,229,146.70
210302	Түлш, халаалт	145,460,327.20	215,315,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,550,593.83	7,053,802.89
210408	Бараа материал акталсны зардал	12,550,593.83	7,053,802.89
2105	Нормативт зардал	45,776,630.00	53,241,420.00
210502	Хоол, хүнс	45,776,630.00	53,241,420.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,940,811.00	11,560,350.00
210604	Урсгал засвар	44,940,811.00	11,560,350.00
2107	Гомилот, зочны зардал	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний гөлбөр, хураамж	10,526,965.57	13,873,546.63
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,526,965.57	13,873,546.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	206,097,142.90	250,101,056.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,961,061.00	41,082,460.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,534,300.00	9,886,728.38
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	172,601,781.90	199,131,867.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,489,610.56	63,663,233.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,220,760.00	54,384,930.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,220,760.00	54,384,930.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	268,850.56	9,278,303.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	268,850.56	9,278,303.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	137,963,700.20	(1,783,196.89)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	119,349,400.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	119,349,400.84
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(119,349,400.84)

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	137,963,700.20	(121,132,597.73)
---	-------------------------	----------------	------------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,625,075,040.00	1,917,940,124.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	9,741,040.00	3,273,524.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,741,040.00	3,273,524.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,741,040.00	3,273,524.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	220,000.00
1200042	Гуулах үйл ажиллагааны орлого	9,741,040.00	3,053,524.00
13	ГУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,615,334,000.00	1,914,666,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,430,089,200.00	1,671,265,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,430,089,200.00	1,671,265,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	185,244,800.00	243,401,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	185,244,800.00	243,401,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	1,561,405,470.57	1,867,254,319.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,561,405,470.57	1,867,254,319.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,520,807,670.01	1,806,398,266.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,110,202,398.00	1,304,084,126.00
210101	Үндсэн цалин	682,136,224.00	721,450,181.00
210102	Нэмэгдэл	383,938,904.00	500,646,857.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	40,825,421.00
210104	Урамшуулал	44,127,270.00	41,161,667.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,599,806.00	159,968,117.00
210201	Тэтгэврийн даатгал	92,189,578.00	111,393,254.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,812,434.00	13,032,187.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,432,590.00	6,516,120.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,279,370.00	5,805,312.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,885,834.00	23,221,244.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,491,838.44	227,544,246.70
210301	Гэрэл, цахилгаан	11,031,511.24	12,229,146.70
210302	Түлш, халаалт	145,460,327.20	215,315,100.00
2105	Нормативт зардал	45,468,250.00	51,140,750.00
210502	Хоол, хүнс	45,468,250.00	51,140,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,484,111.00	8,426,550.00
210604	Урсгал засвар	28,484,111.00	8,426,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний гөлбөр, хураамж	10,526,965.57	13,873,546.63
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,526,965.57	13,873,546.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,034,301.00	41,360,930.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,622,661.00	35,409,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,411,640.00	5,951,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,597,800.56	60,856,053.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,328,950.00	50,657,750.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,328,950.00	50,657,750.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	268,850.56	9,278,303.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	268,850.56	9,278,303.30
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	920,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	920,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	63,669,569.43	50,685,804.37
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,263,500.00	15,445,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,263,500.00	15,445,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,263,500.00	15,445,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,263,500.00	15,445,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(29,263,500.00)	(15,445,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	34,406,069.43	35,240,804.37
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	41,976,211.00	76,382,280.43
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	76,382,280.43	111,623,084.80

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	897,971,845.05	633,959,216.05	1,887,300,169.66	3,419,231,230.76
Тайлант үеийн үр дүн	-	-	137,102,216.85	137,102,216.85
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	897,971,845.05	633,959,216.05	2,024,402,386.51	3,556,333,447.61
Тайлант үеийн үр дүн	-	-	(121,132,597.73)	(121,132,597.73)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	897,971,845.05	633,959,216.05	1,903,269,788.79	3,435,200,849.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Гатаас, санхүүжилтийн орлого	1,936,868,300.00	1,905,388,296.70	31,480,003.30
Улсын төсвөөс	1,691,619,200.00	1,669,417,500.00	22,201,700.00
Орон нутгийн төсвөөс	245,249,100.00	235,970,796.70	-
Гуламжийн орлого	72,827,200.00	3,273,524.00	69,553,676.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,009,695,500.00	1,908,661,820.70	91,755,376.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	1,581,578,800.00	1,464,052,243.00	117,526,557.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,405,742,200.00	1,304,084,126.00	101,658,074.00
Цалин	1,405,742,200.00	1,304,084,126.00	101,658,074.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	175,836,600.00	159,968,117.00	15,868,483.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	175,836,600.00	159,968,117.00	15,868,483.00
Бараа, үйлчилгээний урсгал зардал	182,867,600.00	168,382,976.63	14,484,623.37
Тогтмол зардал	245,249,100.00	235,970,796.70	-
Гэрэл цахилгааны зардал	19,500,000.00	12,229,146.70	-
Түлш, халаалтын зардал	215,315,100.00	215,315,100.00	-
Цэвэр, бохир усны зардал	2,000,000.00	-	-
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	8,434,000.00	8,426,550.00	-
Хоол	51,140,900.00	51,140,750.00	150.00
Бусад бараа үйлчилгээний зардал	56,345,700.00	46,759,380.00	9,586,320.00
Шуудан холбооны зардал	16,797,800.00	13,873,546.63	2,924,253.37
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	5,983,000.00	5,951,550.00	31,450.00
Бусад /үдийн цай/	52,600,200.00	50,657,750.00	1,942,450.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,009,695,500.00	1,868,406,016.33	141,289,483.67
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	71,367,280.43	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	111,623,084.80	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 62,728.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 27,375.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж, 35,353.1 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага тус тус хүргүүлжээ.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Аудитаар тайлант хугацаанд Мобинет ХХК-ийн 30,000,000.00 (гучин сая) төгрөгийн өр төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй, мөн барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д (*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т (*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*;) гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсөвтөө тохируулан өр төлбөрийг барагдуулах хуваарийг гаргаж бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж, төлж барагдуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Аудитаар 2016 оны 139/ ШШ2016/00307 дугаар шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг сургуулийн төсвийн хөрөнгөөс барагдуулсан, төрд учирсан насжилт өндөртэй 4,235,654.00 (дөрвөн сая хоёр зуун гучин таван мянга зургаан зуун тавин дөрвөн) төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т (*Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно*), 20 дугаар зүйлийн 20.2.4-д (*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*;) гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэртэй холбоотой насжилт өндөртэй 4,235,654.00 (дөрвөн сая хоёр зуун гучин таван мянга зургаан зуун тавин дөрвөн) төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэн барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 3: Аудитаар сургуулийн хүнсний материалын тайланд тусгасан хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, дотуур байрны хүүхдийн хоолыг Засгийн газрын тогтоолд зааснаас 1,117,470.00 (нэг сая нэг зуун арван долоон мянга дөрвөн зуун далан) төгрөгөөр илүү зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6-д (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), Засгийн газрын 2024 оны 254 дугаар тогтоолын 2-д (*Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 (зургаан мянга гурван зуу) төгрөгөөр, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000 (зургаан*

мянга) төгрөгөөр тус тус тогтоосугай) гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний материалын тайланг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүртгэх, хоолны зардлыг батлагдсан нормын дагуу тооцож зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх *албан шаардлага хүргүүлсэн.*

3.2 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 12 ширхэг хөрөнгийг бүртгэж, ангилал буруу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг 5 дугаар зүйлийн 5.1-т (*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална*), 5.1.4-д (*үнэн зөв байх*), Сангийн сайдын 2025 оны АЗ дугаар тушаалын хавсралт (*Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*)-д заасантай тус тус нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг бүртгэлд ангилал зөв бүртгэх

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100.0 хувь залруулагдаагүй байна. Нийт 62,728.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь 34,235.6 мянган төгрөгийн нийцлийн аудитын зөрчил, 28,492.50 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 28,492.50 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 7,581.6 мянган төгрөгөөр их байгаа тул “ХЯЗГААРЛАЛТТАЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сургуулийн хүнсний материалын тайланд тусгасан хоолны ордерт хүүхдийн тоо, өдрийн нормыг тэмдэглээгүй, өдрийн норм хэмжээнд засвар хийсэн, дотуур байрны хүүхдийн хоолыг Засгийн газрын тогтоолд зааснаас илүү дүнгээр зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.	1	1,117.5	-	-	1	1,117.5	-	-	-	-
Бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай 12 ширхэг хөрөнгийг бүртгэж, ангилал буруу тайлагнасан байна.	1	27,375.0	-	-	-	-	1	27,375.0	-	-
Дүн	2	28,492.50	-	-	1	1,117.5	1	27,375.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аудитаар тайлант хугацаанд Мобинет ХХК-ийн өр төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй, мөн барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчил илэрлээ.	1	30,000.0	-	-	1	30,000.0	-	-	-	-
2016 оны 139/ ШШ2016/00307 дугаар шүүхийн шийдвэрээр төлсөн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг сургуулийн төсвийн хөрөнгөөс барагдуулсан, төрд учирсан насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй зөрчил илэрлээ.	1	4,235.6	-	-	1	4,235.6	-	-	-	-
Дүн	2	34,235.6	-	-	2	34,235.6	-	-	-	-